

## ТӨСӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА Ерөнхий зүйл

Уг төсөл сонгон шалгаруулалтаар олгох газарт орчин үеийн стандарт **нийцсэн**, шаардлага хангасан барилга байгууламж барих, байгаль орчинд **ямар нэгэн сөрөг нөлөөгүй** хоргүй үйл ажиллагаа эрхлэх, ногоон байгууламж зам талбай барьж байгуулах замаар чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлж, бүс нутгийн нийгэм эдийн засгийг дэмжихэд оршино.

### 1. Гүйцэтгэх ажлын цар хүрээ, хугацаа:

- 1.1 “Замын-Үүд” чөлөөт бүс
- 1.2. Газар эзэмших, ашиглах хугацаа 15 жил
- 1.3.Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь газар эзэмших, ашиглах гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хуанлийн 90 хоногт багтаан барилгын ажлыг гүйцэтгэж эхлэх;

### 2. Төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн шаардлага:

- 2.1.Хөрөнгийн баталгаа, төлбөрийн чадвартай байх.
- 2.2.Оролцогч нь хөрөнгийн баталгаа, төлбөрийн чадвар болон төсөл **сонгон** шалгаруулалтад ирүүлсэн мэдээллийн үнэн зөвийг бүрэн хариуцна.
- 2.3.Мэргэжлийн боловсон хүчний болон техник, тоног төхөөрөмж, технологийн чадавхи, нөөцтэй байх.
- 2.4.Оролцогч нь өөрийн байгууллагын үндсэн мэдээллээ хавсралт төслийн маягтын дагуу бөглөж ирүүлнэ.
- 2.5.Оролцогч нь төслийн шаардлага “Чөлөөт бүсийн тухай хууль” болон бусад эрх зүйн актуудыг нэг бүрчлэн судалж, төслийг зохих шаардлагын дагуу боловсруулан “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албанд **доор** дурдсан хугацаанд багтаан ирүүлнэ.
- 2.6.Оролцогч нь төсөл сонгон шалгаруулалтаар олгож буй газрыг үзэж танилцах, газрын талаар нэмэлт мэдээлэл авах шаардлагатай бол тухайн зард заасан хаяг болон холбогдох дугаараар хандаж болно.
- 2.7. Оролцогч нь Төрийн сангийн /100900036011/ дансанд 12500 /арван хоёр мянга таван зуун төгрөг/ төлсөн байх.

### 3. Төслийн бүрдэл:

Төсөл нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

- 3.1.Аж ахуйн нэгжийн бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар
- 3.2.Төслийн маягт
- 3.3.Төслийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS ISO 21500 стандартын дагуу боловсруулах
- 3.4.Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмших, ашиглах газарт барих барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн эх загвар /эскиз/ зураг
- 3.5.Барилга байгууламжийн инженерийн хангамжийн ерөнхий шийдэл, хүчин чадлыг тодорхойлсон байх
- 3.6.Тухайн төсөл нь байгаль орчин болон хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх
- 3.7.Мөн чөлөөт бүс болон хот, суурин газрын нийгэм, эдийн засгийн хөгжилд нөлөөлөх ач холбогдол, үр ашгийн талаарх тооцоолол

#### **4. Төслийн саналыг бэлтгэх ба баталгаажуулалт:**

- 4.1. Төслийн саналыг давхар дугтуйнд хийж тамгалж ирүүлнэ.
- 4.2. Оролцогч гуравдугаар зүйлд заасан иж бүрдэл бүхий төслийн эх хувь болон хуулбар хувийг “ЭХ ХУВЬ, ХУУЛБАР ХУВЬ” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэн, тэдгээрийг дахин давхар нэг дугтуйнд хийж ирүүлнэ.
- 4.3. Гадна дугтуйн дээр “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албанд гэж хаяглан, 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 12.00 цагаас “ӨМНӨ НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэж тэмдэглэсэн байна.
- 4.4. Доторх дугтуйн дээр санал ирүүлж буй байгууллагын нэр хаяг байна.
- 4.5. Хэрэв саналыг заасны дагуу дугтуйлж ирүүлээгүй тохиолдолд “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба нь хариуцлага хүлээхгүй болно.
- 4.6. Зар мэдээнд заасан хугацаанаас хоцролгүй “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албанд ирүүлнэ.
- 4.7. Оролцогч ирүүлсэн төслөө хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө бичгээр мэдэгдэл өгч өөрийн төслийг буцаан авч болно.